



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

“ХЭЛЭЛЦСЭН нь: Транзит шуудан илгээмжийг БНХАУ-аас ОХУ-руу шууд агаараар түр тээвэрлүүлэх зөвшөөрөл олгох талаар

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“...Ковид-19 цар тахлын идэвхжилтээс шалтгаалан хил, гаалийн хорио цээрийн дэглэм хэрэгжсэн, БНХАУ-ын хил дээр транзит тээврийн түгжрэл үүссэн зэрэг хүндрэлтэй нөхцөл байдлыг харгалзан транзит шуудан илгээмжийг БНХАУ-аас ОХУ-руу шууд агаараар 2020 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 3 сарын хугацаатайгаар түр тээвэрлүүлэх зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцэн дэмжиж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхийг “Монгол шуудан” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд чиглэл болгох нь зүйтэй” гэж үзэв.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР